

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН ПРОГРЕСС СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/13/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Х

khovd@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70432545 Цахим хаяг:

Тунгалаг бүртгэл Аудит ХХК

Аудитор: Ч.Мөнхцооз

Утас: 99028555

Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 ЦамБегарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ПРОГРЕСС
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
З.ЭНХБАЯР ТАНАА

АХАА ОР. АС № 2/187
таних -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын Прогресс сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Прогресс сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үр дүн зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

02102061E

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>129,388,925.87</u>	<u>142,925,841.22</u>
33	АВЛАГА	1,665,086.51	13,910.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,631,486.51	13,910.89
335	Бусад авлага	33,600.00	-
3351	Байгууллагаас авах авлага	33,600.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	127,723,839.36	142,911,930.33
351	Түүхий эд материал	71,400.00	4,326,870.00
35130	Эм боох материал	71,400.00	4,326,870.00
354	Хангамжийн материал	127,652,439.36	138,585,060.33
35410	Бичиг хэргийн материал	1,036,000.00	839,800.00
35420	Аж ахуйн материал	1,811,300.00	1,002,799.70
35450	Барилгын засварын материал	-	1,582,200.00
35470	Бусад хангамжийн материал	124,805,139.36	135,160,260.63
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,750,060,535.94</u>	<u>1,699,988,790.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,750,060,535.94	1,699,988,790.98
392	Биет хөрөнгө	1,626,585,536.02	1,576,601,291.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,553,545,436.29	1,553,545,436.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(70,463,013.27)	(116,603,522.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,223,089.00	217,841,871.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(203,945,080.92)	(211,164,474.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,782,841.00	134,238,276.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,331,166.63)	(85,608,376.20)
39217	Ном	90,773,430.55	84,352,081.04
393	Биет бус хөрөнгө	123,474,999.92	123,387,499.88
39301	Програм хангамж	350,000.00	350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(175,000.08)	(262,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	123,300,000.00	123,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,879,449,461.81</u>	<u>1,842,914,632.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>404,451.30</u>	<u>98,173.14</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	404,451.30	98,173.14
413	Өглөг	404,451.30	98,173.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	98,173.14
4136	Бусад өглөг	366,345.30	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,879,045,009.81</u>	<u>1,842,816,459.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,879,045,009.81	1,842,816,459.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,566,407,787.00	3,566,407,787.00
51101	Өмч: - төрийн	3,566,407,787.00	3,566,407,787.00
512	Хуримтлагдсан үр дүн	(1,826,733,349.29)	(1,862,961,900.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,826,733,349.29)	(1,826,627,749.29)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,334,150.75)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,370,572.10	139,370,572.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,879,449,461.11	1,842,914,632.20

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,428,577,916.30	1,503,807,902.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,465,616.30	37,305,902.71
120	Нийтлэг татварын бус орлого	34,465,616.30	37,305,902.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,756,816.30	37,305,902.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,756,816.30	37,305,902.71
120005	Түрээсийн орлого	2,504,400.00	-
120009	Бусад орлого	1,204,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,394,112,300.00	1,466,502,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,004,020,700.00	1,165,118,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	995,542,300.00	1,165,118,300.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	8,478,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,485,100.00	57,710,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,438,600.00	6,001,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,046,500.00	51,709,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,606,500.00	243,672,900.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	8,478,400.00	-
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	218,128,100.00	243,672,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,426,561,030.90	1,526,135,361.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,561,030.90	1,526,135,361.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,363,741,210.90	1,463,392,279.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	897,940,286.30	1,013,225,763.00
210101	Үндсэн цалин	536,203,086.30	609,022,398.74
210102	Нэмэгдэл	265,180,500.00	309,005,712.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,844,022.00
210104	Урамшуулал	96,556,700.00	67,353,630.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,058,759.24	127,045,205.06
210201	Тэтгэврийн даатгал	77,108,051.69	84,429,264.30
210202	Тэтгэмжийн даатгал	9,071,535.49	12,198,040.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,249,548.40	8,111,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,789,507.60	2,027,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,840,116.06	20,278,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,185,504.00	210,492,450.00
210301	Гэрэл, цахилгаан	4,669,204.00	3,775,586.00
210302	Түлш, халаалт	188,535,600.00	180,338,400.00
210303	Цэвэр, бохир ус	21,980,700.00	26,378,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,033,916.00	7,821,134.00
210401	Бичиг хэрэг	1,066,500.00	1,385,300.00
210402	Тээвэр, шатахуун	147,600.00	144,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,037,539.00	3,500,034.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	413,000.00	460,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,369,277.00	976,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,355,000.00
2105	Нормативт зардал	2,579,430.00	2,258,730.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	321,900.00	1,614,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,257,530.00	644,000.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	140,000.00

Жаргалант сумын Прогресс сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	128,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,033,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,033,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,807,315.36	101,375,997.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,681,900.00	274,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,831,752.70	29,041,610.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,293,662.66	72,059,987.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,819,820.00	62,743,082.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,329,800.00	30,368,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,329,800.00	30,368,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,490,020.00	32,374,182.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,490,020.00	32,374,182.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,016,885.40	(22,327,459.04)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,656,556.74	14,006,691.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,656,556.74	14,006,691.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,656,556.74)	(14,006,691.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(639,671.34)	(36,334,150.75)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,408,166,477.00	1,466,502,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,708,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	3,708,800.00	-
120005	Түрээсийн орлого	2,504,400.00	-
120009	Бусад орлого	1,204,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,404,457,677.00	1,466,502,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,004,020,700.00	1,165,118,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	995,542,300.00	1,165,118,300.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	8,478,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,485,100.00	57,710,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,438,600.00	6,001,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,046,500.00	51,709,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,606,500.00	243,672,900.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	8,478,400.00	-
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	218,128,100.00	243,672,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,345,377.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10,345,377.00	-

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,398,483,677.00</u>	<u>1,466,502,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,398,483,677.00	1,466,502,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,325,400,080.00	1,403,898,118.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	902,080,400.00	1,013,935,100.00
210101	Үндсэн цалин	559,914,053.00	609,022,398.74
210102	Нэмэгдэл	279,613,300.00	309,005,712.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,844,022.00
210104	Урамшуулал	62,553,047.00	68,062,967.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,985,100.00	124,986,464.30
210201	Тэтгэврийн даатгал	74,110,000.00	84,429,264.30
210202	Тэтгэмжийн даатгал	8,718,800.00	10,139,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,975,000.00	8,111,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,743,700.00	2,027,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,437,600.00	20,278,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,766,900.00	226,947,300.00
210301	Гэрэл, цахилгаан	5,137,800.00	5,700,000.00
210302	Түлш, халаалт	189,448,800.00	195,254,400.00
210303	Цэвэр, бохир ус	22,180,300.00	25,992,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,115,800.00	4,966,500.00
210401	Бичиг хэрэг	706,000.00	809,500.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	344,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,222,800.00	1,204,800.00
210404	Ном, хэвлэл	661,000.00	1,084,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,700.00	260,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,021,300.00	1,262,800.00
2105	Нормативт зардал	2,034,320.00	8,694,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	356,200.00	6,664,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,678,120.00	2,030,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,585,200.00	1,585,200.00
210604	Урсгал засвар	1,585,200.00	1,585,200.00
2107	Томилолт, зочны зардал	128,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	128,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	1,266,999.70

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,266,999.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,696,360.00	21,375,954.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,951,000.00	600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,745,360.00	20,775,954.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,083,597.00	62,603,882.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,593,577.00	30,229,700.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10,345,377.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,248,200.00	30,229,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,490,020.00	32,374,182.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,490,020.00	32,374,182.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,682,800.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,682,800.00	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,826,733,349.29)		1,879,045,009.81
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,826,733,349.29)	-	1,879,045,009.81
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,826,733,349.29)	-	1,879,045,009.81
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,826,733,349.29)	-	1,879,045,009.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	105,600.00		105,600.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,826,627,749.29)	-	1,879,150,609.81
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(36,334,150.75)		(36,334,150.75)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,566,407,787.00	139,370,572.10	(1,862,961,900.04)	-	1,842,816,459.06

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,510,913,700.00	1,434,127,818.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,510,913,700.00	1,434,127,818.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,467,774,700.00	1,404,698,118.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,013,935,100.00	1,013,935,100.00
210101	Үндсэн цалин	638,358,500.00	609,022,398.74
210102	Нэмэгдэл	295,107,600.00	309,005,712.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,441,400.00	27,844,022.00
210104	Урамшуулал	67,027,600.00	68,062,967.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,881,100.00	124,986,464.30
210201	Тэтгэврийн даатгал	96,323,900.00	84,429,264.30
210202	Тэтгэмжийн даатгал	10,139,300.00	10,139,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,111,400.00	8,111,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,027,900.00	2,027,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,278,600.00	20,278,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,087,700.00	226,947,300.00
210301	Гэрэл, цахилгаан	5,700,000.00	5,700,000.00
210302	Түлш, халаалт	210,394,800.00	195,254,400.00
210303	Цэвэр, бохир ус	25,992,900.00	25,992,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,626,500.00	4,966,500.00
210401	Бичиг хэрэг	809,500.00	809,500.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	344,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,204,800.00	1,204,800.00
210404	Ном, хэвлэл	744,700.00	1,084,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,700.00	260,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,262,800.00	1,262,800.00
2105	Нормативт зардал	9,034,600.00	8,694,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,664,200.00	6,664,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,370,400.00	2,030,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,585,200.00	1,585,200.00
210604	Урсгал засвар	1,585,200.00	1,585,200.00
2107	Томилолт, зочны зардал	566,600.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	566,600.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,267,000.00	1,266,999.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,267,000.00	1,266,999.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,790,900.00	22,175,954.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	7,596,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,190,900.00	14,579,654.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,139,000.00	29,429,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,139,000.00	29,429,700.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,139,000.00	30,229,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,510,913,700.00	1,434,127,818.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,165,118,300.00	1,132,744,118.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,165,118,300.00	1,132,744,118.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	243,672,900.00	243,672,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	243,672,900.00	243,672,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	102,122,500.00	57,710,800.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,522,500.00	57,710,800.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	79.00	79.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	58.00	58.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78.00	78.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	58.00	58.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20.00	20.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	57,389,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	57,389,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	57,389,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,389,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	57,389,050.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	57,389,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	57,389,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	57,389,050.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын Прогресс сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг сургуулийн захирал З.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлт, төсвийн зардлыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-наас 2021 оны 01 дугаар сарын 24-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Прогресс сургууль нь “Багш сурагчдын тасралтгүй хөгжлийг дэмжин, бие даан суралцах чадвартай, сурлагын хоцрогдолгүй зөв дадал хэвшилтэй иргэнийг эцэг эх, олон нийтийн оролцоотой төлөвшүүлнэ” гэсэн зорилгын хүрэнд үйл ажиллагаа явуулжээ. Үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараа зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.Багш сурагчдын цахим орчинд ажиллах, бие даан суралцах чадварыг дээшлүүлж, массын сургалтын чанарыг 5 хувиар ахиулах

2. Багш сурагчдад хүндлэх, мэндлэх ёсыг дадал болгох

3. Эх оронч үзэлтэй, байгальд ээлтэй, хөгжсөн иргэнийг төлөвшүүлэх гэсэн зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын Прогресс сургуулийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж 4211481 төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 1289881 төгрөгийг төлүүлэх акт, 2921600 төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгчээ.

Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1529940,3 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 15299,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын Прогресс сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36534,8 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын болон үндсэн хөрөнгийн дансдуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,665,087	13,911	1,651,176
Бараа материал	127,723,839	142,911,930	-15,188,091
Үндсэн хөрөнгө	1,750,060,536	1,699,988,791	50,071,745
Нийт хөрөнгө	1,879,449,462	1,842,914,632	36,534,830
Өр төлбөр	404451	98173	306,278
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,879,045,011	1,842,816,459	36,228,551
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,879,449,462	1,842,914,632	36,534,830

Авлага дансны үлдэгдэл 1651,1 мянган төгрөгөөр буурсан нь НДШ, ХОАТ-н бололн хувь хүнээс авах цалингийн тооцооны авлага тус тус барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 15188,0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой эм ариутгах хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой 4255,4 мянган төгрөгөөр өссөн, барилгын засварын материал засвар үйлчилгээ хийгээгүйтэй холбоотой 1582,2, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл боловсрол соёлын газраас ирсэн сурах бичиг, хэрэглэгдэхүүн, утаанаас хамгаалах зориулалтаар 14916,0 мянган төгрөгийн үнэ бүхий 132 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасан, гадна талбайн 2 гэрэлтүүлэг, усгалтын шланк, кабинет тохижуулалтын материалууд зэргийн үлдэгдэл өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50071,7 мянган төгрөгөөр буурсанд тайлант жилийн элэгдлийн зардал 72059,9 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2280,0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий хөгжим, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаан бүрд ХХК-ны бэлтгэн нийлүүлсэн 15576,3 мянган төгрөгийн үнийн дүнтэй сурагчийн ширээ сандал, Дэлхийн зөн ОУБ-аас нийлүүлсэн 5366,9 мянган төгрөгийн үнийн дүнтэй офиссын ширээ сандал зэрэг үндсэн хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусган тайлагнажээ. Эдгээр хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн нөлөөллөөс үндсэн хөрөнгө данс дүнгээрээ буурсан байна.

Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	1,004,020,700	1,165,118,300	161,097,600
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	226,606,500	243,672,900	17,066,400
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	30,756,816	37,305,903	6,549,086
бусад орлого, санхүүжилт	167,193,900	57,710,800	(109,483,100)
Үйл ажиллагааны орлогын дүн	1,428,577,916	1,503,807,902	75,229,986

Жаргалант сумын Прогресс сургуулийн нийт орлого өмнөх оноос 75229,9 мянган төгрөгөөр буюу 5,2 хувиар өссөн байна. Улсын төсвийн санхүүжилт Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй хамааралтай өсчээ.

Орон нутгийн төсвийн санхүүжилт 17066,4 мянган төгрөгөөр буюу 7,5 хувиар өссөн нь цахилгаан, цэвэр бохир усны үнийн өсөлттэй холбоотой байна.

Байгууллагын үйл ажиллагааны орлогоос 102122,5 мянган төгрөг орохоор төлөвлөсөн боловч цар тахлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсанаас гүйцэтгэлээр 51709,5 мянган төгрөг оржээ.

Сурах бичгийн түрээсийн төлбөрөөр нэмэлт дансанд 6001,3 мянган төгрөг орж ирснийг БСУГ-ын данс руу хийсэн байна.

Хүснэгт 3 зардлын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	1,010,999,046	1,140,270,968	129,271,923
Байр ашиглалттай холбоотой зардал	215,185,504	210,492,450	(4,693,054)
Хангамж бараа материалын зардал	4,033,916	7,821,134	3,787,218
нормативд зардал	2,579,430	2,258,730	(320,700)
Бусад бараа үйлчилгээний зардал	187,273,115	132,917,897	(54,355,218)
бусад урсгал шилжүүлэг	6,490,020	32,374,182	25,884,162
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,426,561,030	1,526,135,361	99,574,331

Нийт зардал өмнөх оноос 99574,3 мянган төгрөгөөр буюу 6,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 129271,9 өсөж, бусад урсгал

зардал 29697,5 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа хойшилсон, усны төлбөрийг хагас сараар хөнгөлсөн, бусад цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1510913,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1510913,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1510913,7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1510913,7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 1165118,3 орон нутгийн төсвөөс 243672,9 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 102122,5 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1165118,3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 243672,9 мянган төгрөг, байгууллагын үйл ажиллагааны орлогоос 51709,5 мянган төгрөг нийт 1460500,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 142812,6 мянган төгрөгийг зарцуулж 32374,1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар 57389,0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэнээс 6001,3 мянган төгрөг нь сурах бичгийн түрээсийн орлого үлдэх 51387,7 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний орлого цуглуулан үндсэн данс руу төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрийн орлогоос хамаарч төсөв хэтэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн нь хэрэгжсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4300,6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4300,6 мянган төгрөгийн алдааг залруулж, бараа материалын тайлан, тооцоо бодолт, анхан шатны

баримт бүрдүүлэлттэй холбоотой 2 чиглэлийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 2019 оны санхүүгийн тайланд Хатан түнгэл ХХК-нд 940,8, Ховд скай ХХК-нд 1164,8 бүгд 2105,6 мянган төгрөгийн үдийн цайны мөнгө илүү шилжүүлснийг тайланд тусгаагүй, Мөн өмнөх оны санхүүгийн тайланд Бадамлах Оюу ХХК-нд үдийн цай нийлүүлсэн тооцооны өглөг 2000,0 мянган төгрөгийг тусгаагүй зэрэг 4105,6 мянган төгрөгийн залруулгыг хийлээ. / өнгөрсөн онд шилжүүлэх дүн нэхэмжилсэн дүн 2-ыг сольж программд оруулсантай холбоотой./
- Сургалтын төлбөрийн орлого 195,0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэнийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:

Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 800.0 мянган төгрөгийн маскийг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал.

1.1. **Илрүүлэлт:** Эд хариуцагчийн тайлан гаргалт хангалтгүй, тооцоог актаар баталгаажуулаагүй

1.2. **Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх

1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д заасан анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

2.2. **Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн/ мян.төг/	Аудитын байгуул- лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хатан түнгэл ХХК, Ховд Скай ХХК-ны 2019 оны авлага тайланд тусгаагүй.	2,105.6	залруулга	захирал	З.Энхбаяр
2	Бадамлах Оюу ХХК-ны 2019 оны өглөг тайланд тусгаагүй.	2,000.0	залруулга	захирал	З.Энхбаяр
3	Сургалтын төлбөрийн орлого дутуу бүртгэсэн	195.0	залруулга	захирал	З.Энхбаяр
4	Эд хариуцагчийн тооцоог актаар баталгаажуулаагүй	-	Зөвлөмж	захирал	З.Энхбаяр
5	НӨАТ-н баримт дутуу	-	Зөвлөмж	захирал	З.Энхбаяр
	НИЙТ ДҮН	4,300.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР